

БАТЛАВ:

"РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ"  
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

С.ЦАГААНХҮҮ  
(ЗАХИРАЛ)



Л.ДАВААЖАРГАЛ  
(ЗАХИРАЛ)

### ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2021 оны 06-р сарын 09 өдөр

Дугаар Худалдагч

Улаанбаатар хот

Нэг талаас "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТУГазар /цаашид "Худалдан авагч" гэнэ/ түүнийг үндсэн дээр төлөөлөн Хангамж үйлчилгээний албаны дарга ажилтай Э.Энхгэрэл, Нэгөө талаас /цаашид "Худалдагч" гэнэ/ түүнийг үндсэн дээр төлөөлөн "Сорано томо" ХХК-ын менежер ажилтай Л.Ганбаатар нар дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

#### 1. Нийтлэг заалт

- 1.1. Гэрээний нөхцөлийн дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй фидер кабель нийлүүлэх /цаашид "бараа материал" гэнэ/ түүнтэй холбоотой баримт бичгийг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, Худалдан авагч нь бараа материалыг хүлээн авч, төлбөрийг хийнэ.
- 1.2. Хэмжээ: Фидер кабель 7/8 400 метр
- 1.3. Нийт нээлт орсон үнэ: 7.920.000 /долоон сая есөн зуун хорин мянган төгрөг/

#### 2. Худалдагчийн үүрэг

Худалдагч нь дараахь үүрэг хүлээнэ.

- 2.1. 2022 оны 6-р сарын 13-наас хэтрүүлэлгүй чанрын шаардлага хангасан бараа материалыг Худалдан авагчид шилжүүлнэ.

#### 3. Худалдан авагчийн үүрэг

Худалдан авагч дараахь үүрэг хүлээнэ.

- 3.1. Худалдагчаас хөрөнгийг шилжүүлэх хугацааг мэдэгдсэнээс хойш 1 хоногийн дотор бараа материалыг хүлээж авна.
- 3.2. Худалдан авсан бараа материалыг шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлыг Худалдагчид мэдэгдэнэ.
- 3.3. Худалдаж авсан бараа материалын төлбөрийг төлөх үүрэгтэй.

#### **4. Тооцоо хийх журам**

4.1. Худалдан авагч бараа материалыг хүлээн авсанаас хойш 3 хоногийн дотор 100 хувь төлбөрийг Голомт банкны 1415127920 тоот дансанд Худалдагчид шилжүүлнэ..

#### **5. Хөрөнгө шилжих**

5.1. Худалдсан бараа материалыг Худалдан авагчид шилжүүлснээр хөрөнгө устгаж, гэмтсэний эрсдэл Худалдан авагчид шилжинэ.

#### **6. Талуудын хариуцлага**

6.1. Худалдагчийн буруугаас доголдолтой бараа материал шилжүүлсэн бол уг доголдлыг арилгах үүрэг хүлээн бөгөөд доголдолтой бараа материалын үнийн дүнгийн 5 хувиар тогтоон Худалдан авагчид торгууль төлнэ.

6.2. Энэ гэрээний нөхцлийг зөрчинеөс аль нэг талууд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, ирээдүйд олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан тал батална.

#### **7. Давагдашгүй хүчин зүйл**

7.1. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гол түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үйлмээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт-/ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгэр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулах болно.

7.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан, тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

#### **9. Маргааныг шийдвэрлэх**

9.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцо замаар шийдвэрлэнэ.

9.2. Талууд тохиолцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **10. Гэрээний үйлчлэх хугацаа**

10.1. Гэрээний үйлчлэх хугацаа 2022 оны 6 дугаар сарын 9-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр хүртэл байна.

10.2. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал бичгээр тохиролцсоноор сунгаж болно.

10.3. Гэрээний үйлчлэх хугацааг дараах тохиолдолд зогсоож болно.

- Талуудын зөвшилцсөнөөр;
- Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр ;
- Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр.

#### **11. Гэрээний хавсралт**

Доорхи хавсралт нь гэрээний салшгүй хэсэг мөн.

11.1. Хавсралт № 1 \_Үнийн санал

1 хуудас

#### **12. Бусад заалт**

- 12.1. Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.  
12.2. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

### 13. Талуудын хаяг

Захиалагчийг төлөөлж:



Хангамж үйлчилгээний албаны дарга  
/ Э.Энхгэрэл/  
Утас: 75112020

Хаяг: БГД, 17-р хороо, Амарсанаагийн  
гудамж өөрийн байр  
Улаанбаатар хот, Монгол улс

Гүйцэтгэгчийг төлөөлж:



Инженер  
/ Л.Ганбаатар/  
Утас: 80198685

Хаяг: БЗД, 15-р хороолол, 7-р хороо,  
23 байр 4-00 тоот  
Улаанбаатар хот, Монгол улс

# СОРАНО ТОМО

2022 он 06-р сарын 02 өдөр

Дугаар 22/09

Улаанбаатар хот

“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” УТУГ-Т

Үнийн санал:

| Д/д | Бараа материал   | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|-----|------------------|-------------|------------|-------------|----------|
| 1   | Фидер кабель 7/8 | м           | 400        | 18000       | 7200000  |
|     | Бүгд             |             |            | дүн         | 7200000  |
|     |                  |             |            | НӨАТ 10%    | 720000   |
|     |                  |             |            | НИЙТ ДҮН    | 7920000  |

Хүндэтгэсэн:



